

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**

**ШУТИС-2015 ОН  
МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Улаанбаатар хот  
2008 он  
АГУУЛГА**

## **Оршил**

### **Нэгдүгээр бүлэг. ШУТИС-ийн хөгжлийн өнөөгийн байдал, оношлогоо, дүгнэлт**

- 1.1. ШУТИС-ийн 2001-2010 он хүртэлх Мастер төлөвлөгөөний хэрэгжилт, бодит байдлын үнэлгээ
- 1.2. Өнөөгийн байдлаас хийх нэгдсэн дүгнэлтүүд

### **Хоёрдугаар бүлэг. ШУТИС-ийн 2015 он хүртэлх хөгжлийн стратеги, үндсэн зорилго, зорилтууд**

- 2.1. Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс
- 2.2. Стратегийн зорилго, зорилтууд

### **Гуравдугаар бүлэг. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, шалгуур үзүүлэлт**

- 3.1. Сургалтын үйл ажиллагааг төгөлдөржүүлэх
- 3.2. Шинжлэх ухаан, технологийн ба инновацийн хөгжлийг эрчимжүүлэх
- 3.3. Нийгэмд үзүүлэх үйлчилгээг бүх талаар чанаржуулан өргөжүүлэх
- 3.4. Менежментийн чадавхийг сайжруулах
- 3.5. Хүмүүн капиталын тогтвортой хөгжлийг хангах
- 3.6. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх

### **Дөрөвдүгээр бүлэг. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, хяналт-үнэлгээ ба санхүүгийн нөөц**

- 4.1. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, хяналт, үнэлгээ
- 4.2. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн нөөц ба эрсдэл

### **Хавсралт материалууд**

- а/. Бүрэлдэхүүн сургуулиудын хөгжлийн стратеги
- б/. Мастер төлөвлөгөөнд холбогдох хавсралтууд
- в/. Нэр томъёоны тайлбар толь

**ОРШИЛ**

“Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”, “Монгол улсын Шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө” зэрэг манай орны боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэхээр гаргасан стратегийн баримт бичгүүдэд тулгуурлаж, сургуулийнхаа хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшинд суурилж “ШУТИС-2015 он Мастер төлөвлөгөө”-г боловсруулж, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2008.01.23-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэхээр болж байна.

“ШУТИС-2015 он Мастер төлөвлөгөө” нь ШУТИС-ийн хөгжлийн стратегийн үндсэн баримт бичиг мөн бөгөөд ШУТИС-ийн 2008-2015 онд баримтлах урт хугацааны стратегийн зорилт, үндсэн чиглэлийг тодорхойлж, түүнд хүрэх арга зам, хэрэгжүүлэх үйл ажиллагааг шаардагдах нөөц, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хамт тодотгон танилцуулж байна.

Энэхүү Мастер төлөвлөгөөний гол агуулга нь нийгмийн эрэлт хэрэгцээг мэдрэн, оюуны капиталаа хөгжүүлэх замаар мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжлийг хангахад өөрийн үйл ажиллагааны хүрээнд бодитой хувь нэмэр оруулж, улмаар олон улсын хэмжээнд байр сууриа бэхжүүлэн хөгжүүлэхэд оршиж байна. Энэ нь Монгол улсад техник, технологийн чиглэлээр судалгаа, сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа хамгийн том их сургуулийн хувьд өндөр чадавхитай мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, үйл ажиллагааныхаа чанар, үнэлэмжийг дээшлүүлэх бодит боломжийг бүрдүүлж, түүнийг үр ашигтай, оновчтой ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чиглэгдэх болно.

ШУТИС-ийн эвсэг, оюунлаг хамт олны бүтээлч санаачлага, байнгын хүчин чармайлт, бодит үйл хэрэг, хүсэл тэмүүлэл дүүрэн үйл ажиллагааны үр дүнд энэхүү зорилтыг амжилттай хэрэгжүүлэх болно. Дэвшүүлсэн зорилго, төлөвлөсөн үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, сэтгэл нийлэн хамтдаа урагшлан хөгжихийг хөдөлгөгч гол хүч болсон эрдэмтэн багш, ажилтан, оюутан суралцагч Та нартаа уриалж байна.

Энэхүү Мастер төлөвлөгөөг боловсруулахад сэтгэл, оюунаа зориулсан ажлын хэсэгт болон олон шатны хэлэлцүүлэгт идэвхитэй оролцсон нийт профессор, багш нарт гүн талархал илэрхийлье.

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН  
РЕКТОР БАЯНДҮҮРЭНГИЙН ДАМДИНСҮРЭН

## **Нэгдүгээр бүлэг. ШУТИС-ИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОНОШЛОГОО, ДҮГНЭЛТ**

### **1.1. ШУТИС-ийн 2001-2010 он хүртэлх Мастер төлөвлөгөөний хэрэгжилт, бодит байдлын үнэлгээ**

ШУТИС-ийн Ректорын зөвлөл, хамт олны санаачлагаар тус сургуулийг 2010 он хүртэл хөгжүүлэх хоёрдахь Мастер төлөвлөгөөг хөгжлийн ерөнхий стратеги, үйл ажиллагааы 5 чиглэлээр боловсруулж Эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулан, хэрэгжүүлж ирсэн.

Уг төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг сургуулийн Ректорын зөвлөл, Эрдмийн зөвлөлийн хурлаар хэд хэдэн удаа хэлэлцсэн бөгөөд сүүлийн хэлэлцүүлгийг 2007 оны 6 дугаар сард хийж, ШУТИС-2015 он хөгжлийн шинэ Мастер төлөвлөгөө боловсруулах удирдамж чиглэл өгөгдсөн.

ШУТИС-ийн 2010 он хүртэлх Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг юуны өмнө дээд боловсролын байгууллагын үйл ажиллагааг дүгнэх аргачлалын дагуу сүүлийн 10 жилийн хөгжлийн үзүүлэлтүүдээр дүгнэлээ. Мөн манай улсын томоохон их сургуулиудын үзүүлэлтүүдтэй харьцуулан судалж үзэхэд, ШУТИС нь ихэнхи үзүүлэлтээрээ тэргүүлэх байр суурийг эзэлж байгаа ба ихэнхи индексүүд тогтвортой, хөгжлийн үзүүлэлтүүд бага зэргийн өсөх хандлагатай байгаа /Хавсралт №1/ боловч эдгээр индексүүдийг ашиглан дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаанд өгдөг үнэлгээг тооцож үзвэл ШУТИС-ийн ерөнхий үнэлгээ нь байвал зохих түвшнээс доогуур байна. Гэхдээ тус сургууль нь нийт суралцагч оюутны тоо, төгсөгчдийн тоо, бэлтгэж буй мэргэжлийн тоо, нийт ажиллагчдын тоо, нийт багш нарын тоо, жилийн нийт орлого, зардлын хэмжээ, үндсэн ба эргэлтийн хөрөнгийн хэмжээгээр Монгол улсын дээд боловсролын байгууллагуудын дотор нэгдүгээрт орж байна. Харин нийт багш нарын дотор эрдмийн зэрэг цолтой багш нарын эзлэх хувь хэмжээ, шинжлэх ухаан, технологийн төслийн хэрэгжилт, үр дүн, бүтээл туурвилтын тоо зэрэг үзүүлэлтээр бусад их сургуулиудтай харьцуулахад тэргүүлэх байр суурь эзэлж чадаагүй байна. Түүнчлэн оюутнуудыг төгсгөх талаар анхаарал хандуулах шаардлагатай байна.

ШУТИС-ийн өнөөгийн байдлын үнэлгээ, хүрсэн түвшинд хийсэн SWOT, PEST шинжилгээнүүдээс үзэхэд, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж буй өнөөгийн байдал нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ, эдийн засгийн бүтэц, онцлогтой бүрэн уялдаж чадахгүй байна. Сургуулийн үйл ажиллагааг үндэсний үйлдвэрлэл, технологийн хөгжлийг дэмжих, үндэсний эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй бүрэн нийцүүлэх шаардлагатай. Мөн төрийн оролцоо, зохицуулалтын үүргийг хангахад ШУТИС-иас нөлөөлөх стратегийг хэрэгжүүлж чадахгүй байгаа нь харагдав.

ШУТИС-ийн хоёрдахь Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх явцад анхаарал татсан нэгэн зүйл бол уг Мастер төлөвлөгөөг сурталчлах, таниулах талаар авсан арга хэмжээ

бага, хугацааны туршид хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлтүүдийг гаргаж байгаагүй явдал юм. Энэ нь төлөвлөгөөт зорилтуудыг биелүүлэх, шалгуур үзүүлэлтүүдийг хангах боломжийг алдагдуулахад хүргэсэн байна. Түүнчлэн зорилтын хүрэх үр дүнг үндэслэлгүй өндөр төлөвлөснөөс хэрэгжилтийн хувь доогуур байна. Тухайлбал, 2005 онд нийт суралцагчдын дотор магистр, доктор оюутны эзлэх хувийг 15 болгох зорилт тавьсан нь 7.3 хувьтай гарсан байна. Мөн 2010 онд дээрх үзүүлэлтийг 20%-д хүргэх зорилт дэвшүүлсэн нь 8 хувиас хэтрэхгүй төлөвтэй байна. /Хавсралт №2/

ШУТИС-ийн хэмжээнд өнөөдөр 20 гадаад оюутан суралцаж байгаа нь гадаад оюутны хувийн жинг 3-5% - д хүргэхээр дэвшүүлсэн зорилт биелэх боломжгүй байгааг харуулж байна.

Докторын зэрэгтэй багшийн тоог 2005 онд нийт багшийн 50%, 2010 онд 80%-д хүргэнэ гэсэн зорилт тавьсныг дүгнэж үзэхэд 2005 онд 27%, 2010 онд 32.8%-ийн биелэлттэй байхаар байна.

Мастер төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх явцад статистикийн судалгаанаас гадна хамт олны дунд асуулгаар судалгаа явуулж дүгнэв. Энэхүү судалгааг ШУТИС-д ажиллаж буй удирдах ажилтан, профессор багш нийт 303 хүнээс 9 асуулттай тусгайлан бэлтгэсэн асуулгаар явуулсан /Хавсралт №3/. ШУТИС-ийн 2010 он хүртэлх Мастер төлөвлөгөөний хэрэгжилт өнөөгийн байдлаар /төлөвлөгөөний хугацаа дуусахад 2 жил дутуу байхад/ 42 хувьтай, үйл ажиллагааны үндсэн таван чиглэлийн хэрэгжилтийн дундаж түвшин 47.9 хувьтай байна. 2015 оныг дуусталх Мастер төлөвлөгөө боловсруулах шаардлагыг тодруулсан асуултанд судалгаанд оролцогчдын 34 хувь нь тун зүйтэй, 51 хувь нь шаардлагатай гэж хариулсан. Цаашилбал, 2015 он хүртэлх Мастер төлөвлөгөө боловсруулах үед анхаарах гол асуудлууд, өмнөх төлөвлөгөөний чиглэлүүдийг нэмэх болон өөрчлөх талаар багагүй саналууд ирсэн.

## **1.2. Өнөөгийн байдлаас хийх нэгдсэн дүгнэлтүүд**

- ШУТИС өнөөдөр Монгол улсын тэргүүлэх их сургуулийн нэг болох хөгжлийн түвшинд хүрч, улс орны эдийн засгийн гол салбаруудад шаардлагатай техник технологийн мэргэжилтнүүдийг бэлтгэдэг сургалтын арга, технологи, багш судлаачдын зохих потенциал бүхий байгууллага болон хөгжиж байна. Хэдийгээр хөгжлийн ерөнхий хандлага тогтвортой хэрэгжиж байгаа ч тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх зорилтууд багагүй байна. Юуны өмнө глобаль орчин, олон улсын

интеграцлалд эрчимтэй нэгдэн орох, мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжлийн шинэ шаардлагад чиглүүлэн үйл ажиллагаагаа өөрчлөн шинэчлэх шаардлагатай.

- ШУТИС-ийн хэмжээнд Сургалтын кредит системийг 1999-2000 оны хичээлийн жилээс эхлэн бүрэн утгаар нь нэвтрүүлсэн явдал бол бидний өнөөдрийн хүрсэн ололт, амжилт болоод өөрчлөлт, шинэчлэлийн эх үндэс суурь болсныг тэмдэглэхэд таатай байна. Дэлхий дахинаа нэртэй гадаадын их, дээд сургуулиудын мэргэжилтэн бэлтгэн гаргаж буй сургалтын төлөвлөгөөнд судалгаа хийж харьцуулан, үнэлэлт, дүгнэлт хийсний үндсэн дээр шинжлэх ухаан-сургалт-үйлдвэрлэлийн интеграцийг хангах, онол практикийн мэдлэгийн зохистой харьцааг тогтоох зарчмыг баримтлан, сургалтын агуулгын шинэчлэлийг хийж байгаа хэдий ч, хэрэгжилтийн үйл явц удаашралтай, мэргэжилтэн бэлтгэж буй сургалтын орчин, материаллаг бааз бодит хэрэгцээнээс хоцрох хандлагатай байна.
- Ахисан түвшний сургалтын хүрээнд ч магистрантурт суралцах оюутны тоо мэдэгдэхүйц өсөж чадсангүй. Энэ нь ахисан түвшинд суралцах нийгмийн эрэлт хэрэгцээ эрчимтэй өсөөгүйтэй нэг талаас холбоотой ч, нөгөө талаас өнөөгийн сургалтын төлөвлөгөөний агуулга, сургалтын зохион байгуулалт нь нийгэм, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тэр бүр хангахгүй, ахисан түвшинд зориулагдсан сургалтын орчин шаардагдах түвшинд хүрээгүйтэй холбоотой.
- Өнгөрсөн жилүүдэд эрдэм шинжилгээ, технологийн үйл ажиллагааны 2015 он хүртэлх хөгжлийн хөтөлбөр боловсруулагдаж, улсын төсөвт ба гэрээт эрдэм шинжилгээ, технологийн үйл ажиллагааг удирдах удирдлагын тогтолцоо зохих түвшинд шинэчлэгдээд байна. Гэхдээ эрдэм шинжилгээний лаборатори, төвүүдийн төрөлжилт явцуу, улс орны нийгэм эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдэд хөрөнгө, хүчийг төвлөрүүлж чадаагүй, бүрэлдэхүүн сургууль бүрийн судалгаа - үйлдвэрлэлийн холбооны хөгжил харилцан адилгүй, судалгааны ажил ба ахисан түвшний сургалтын уялдаа холбоо сул, эрдэм шинжилгээ, технологийн гадаад хамтын ажиллагааны боломжийг үр дүнтэй ашиглах зэрэг асуудлууд тулгамдаж байна.
- ШУТИС-ийн сургалтын орчин, оюутанд зориулсан нийгмийн олон талт үйлчилгээ нилээд сайжирч байгаа боловч, иргэний нийгмийн өндөр боловсролтой мэргэжилтнүүдийг төлөвшүүлэх таатай орчинг бүрдүүлэх, мөн гадаад оюутнуудын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Их сургуулийн судалгаа, сургалтын орчинг бүрдүүлэх, технологийн инкубатор, технологи дамжуулах төв, шинжлэх ухааны парк

зэрэг их сургуулийн дэд бүтцийг байгуулах нь бидний нийгэмд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх тэргүүлэх чиглэлийн зорилт болж байна.

- 2010 он хүртэлх Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаанд докторын зэрэгтэй багш нарын хувийн жин уг төлөвлөгөөнд тусгасан хэмжээнд хүрэхгүй нь тодорхой байна. Профессор багш, судлаачдын дундаж нас нэмэгдэж байгаагийн зэрэгцээ зарим сургууль, мэргэжлийн чиглэлүүдээр залуу багш нарын тогтвор суурьшил буурсан сөрөг хандлагууд ажиглагдаж байна. Мөн профессор багш нар, ажилтнуудын ажлыг үнэлж дүгнэх, урамшуулах тогтолцоо сул байгаагаас хүн бүрийн хариуцлага, идэвхи зүтгэл харилцан адилгүй байна. Багш, ажиллагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, орон сууцны хангамжийг сайжруулах хөтөлбөрийг эрчимтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- ШУТИС-ийн удирдлагын тогтолцоо ерөнхийдөө төвлөрлийг сааруулах чиглэлээр шинэчлэгдэж иржээ. Гэхдээ төвлөрлийн түвшин нь эцсийн зорилго биш бөгөөд түүний үр өгөөжийн асуудал онцгой чухал учраас шинэ Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад удирдлагын төвлөрөл ба бие даасан байдлын зохистой харьцааг бүрдүүлэхэд онцгой анхаарал хандуулж байна.
  - Санхүү, эдийн засгийн хувьд, ШУТИС-ийн орлого, хуримтлал нэмэгдэж, материаллаг бааз өргөжиж байгаа тоон үзүүлэлтүүдийн өсөлтийн хандлага байна. Гэхдээ сургуулийн дотоодод санхүү, эдийн засгийн удирдлагыг боловсронгуй болгох, чадавхиа нэмэгдүүлэх, гадна талдаа төрийн дэмжлэгийг илүү тодорхой, бодлого чиглэлтэй авах тулгамдсан зорилтууд байна.
  - Инженерийн боловсролыг дэмжих, ШУТ-ийн хөгжлийг эрчимжүүлэх тулгамдсан шаардлагыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн бодлого, зохицуулалтыг чиглэл зорилготойгоор улам тодорхой болгох, улсаас хийх бодит хөрөнгө оруулалт санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай юм.
  - Санхүүгийн төлөвлөлт, бүртгэл, тайлангийн одоогийн тогтолцоо академик үйл ажиллагаа голлосон их сургуулийн хөгжлийн шатанд тохирч байсан бол өнөөгийн нөхцөлд, тухайлбал сургалтаас гадна судалгааны ажил, нийгэмд үйлчлэх бусад үйлчилгээний үүрэг эрчимтэй нэмэгдэж байгаатай уялдан өөрчлөлт хийх шаардлага тулгарч байна. Эдийн засгийн удирдлага, төлөвлөлтөнд хөрөнгийн, материалын, орон тооны үндэслэл сайтай нормативуудыг ашиглах шаардлагатай.

- Хөгжлийн нэг гол арга хэрэгсэл болохын хувьд гадаад харилцаа, хамтын ажиллагаанд урьдын адил анхаарал хандуулахын хамт ШУТИС-ийн олон улс, бүс нутгийн их сургуулиудын сүлжээнд оролцох байдлыг өргөтгөх, байр суурийг дээшлүүлэхэд чиглэсэн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Сургуулийн хөгжлийн өнөөгийн оношлогооноос харахад ШУТИС-ийн хөгжлийн 2015 оны Мастер (шинэ) төлөвлөгөөг глобаль орчин, бүс нутгийн сүлжээнд эзлэх байр суурийг өргөжүүлсэн, улс орны хөгжлийн цогц бодлого, зах зээлийн эрэлт хэрэгцээг соргог мэдэрсэн, эрчимтэй шинэчлэгдэх хүний болон оюуны капиталдаа тулгуурласан, тогтвортой хөгжлийн баримт бичиг байдлаар боловсруулах шаардлагатай. Уг баримт бичгийг боловсруулахдаа өмнөх Мастер төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн туршлага, сургамжийг харгалзан үзэх нь зүйтэй.

### **Хоёрдугаар бүлэг. ШУТИС-ИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ, ҮНДСЭН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД**

ШУТИС-ийн хөгжлийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

### **ШУТИС-ИЙН АЛСЫН ХАРАА**

**ШУТИС-ийн хөгжлийн алсын хараа нь олон улсын жишигт дийцсэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн төв – нээлттэй, сонгодог их сургууль болоход чиглэгдэнэ.**



## **ШУТИС-ИЙН ҮНЭТ ЗҮЙЛС**

**Хүмүүнлэг үзэл баримтлал  
Уламжлал ба шинэчлэл  
Хүмүүний болон оюуны капитал  
Чанар, ил тод, хариуцлагатай байдал  
Шинэ бүтээлч сэтгэлгээ**



## **ШУТИС-ИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО**

**ШУТИС-ийн эрхэм зорилго нь зах зээлийн эрэлт хэрэгцээг мэдэрч, гадаад, дотоодод өрсөлдөх чадвартай мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэн, мэдлэг ба инновацид тулгуурласан оюуны капиталгаа эрчимтэй хөгжүүлэх замаар улс орны мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэсэн чанартай, ир ашигтай, тогтвортой йлчилгээ ижиллэхэд оршино.**




## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ – 2015 он МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, СТРАТЕГИ

### ЭРХЭМ ЗОРИЛГО:

ШУТИС-ийн эрхэм зорилго нь зах зээлийн эрэлт хэрэгцээг мэдэрч, гадаад, дотоодод өрсөлдөх чадвартай мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэн, мэдлэг ба инновацид тулгуурласан оюуны капиталаа эрчимтэй хөгжүүлэх замаар улс орны мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэсэн чанартай, үр ашигтай, тогтвортой үйлчилгээ үзүүлэхэд оршино.

### Хөгжлийн зорилго


Мэдлэгийн зуун, глобал зах зээлийн эрэлт хэрэгцээ, улс орны хөгжлийн хэтийн төлөвт нийцүүлэн, бүтээлч сэтгэлгээтэй, чадварлаг мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэж, мэдлэгийн тившинг баталгаажуулагч байна.



### Зорилтууд


- Зорилт 1.1.** Их сургуулийн сургалтын чанарыг дээшлүүлэх чиглэлд сургалтын ийл ажиллагааг тегелдержүүлэх
- Зорилт 1.2.** Их сургуулийн сургалтын технологийг E-Сургалт, U-Сургалтын шинэ технологиор баяжуулж, сургалтын нэг үндсэн хэлбэр болгон төлөвшүүлэх замаар Нээлттэй их сургууль байгуулах үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Зорилт 1.3.** Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх, тэднийг насан туршийн суралцагч болгох сургалтын тогтолцоог боловсронгуй болгох
- Зорилт 1.4.** Дэлхий дахины дээд боловсролын төрөл бүрийн сүлжээнд нэгдэн орж, олон улсын түвшний шинжээчдээр сургалтын хөтөлбөрийг үнэлүүлж, дүгнүүлэх

Эрдэм шинжилгээ, технологийн үйл ажиллагааг эрчимжүүлж, инновацийг дэмжиж, шинжлэх ухааныг хөгжүүлнэ.




- Зорилт 2.1.** Эрдэм шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэлийг оновчтой болгож, судалгаа, туршилт зохион бичгээр ийл ажиллагааг эрчимжүүлэх.
- Зорилт 2.2.** Профессорын багийн ийл ажиллагааг тегелдержүүлэх.
- Зорилт 2.3.** Эрдэм шинжилгээний лаборатори, материаллаг баазыг бэхжүүлэх.
- Зорилт 2.4.** Оюуны капиталыг бизнесийн эргэлтэнд оруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, эрдэмтэд, судлаач багш, оюутнуудын судалгааны ажлын үр дүнг дэмжин урамшуулах
- Зорилт 2.5** Инновацийн дэд бичгийн нэгжидийн ийл ажиллагааг эрчимжүүлэх, технологи бизнесийн инкубаторуудыг байгуулахад аж ахуйн нэгжидийг ергенеэр татан оролцуулах, уг чиглэлд их сургуулийн өөрийн нөөц боломжийг дайчлан ашиглах.
- Зорилт 2.6.** Магистрантур, докторантурын сургалт судалгааны ажлыг чанаржуулах.

Менежментийн чадавхийг хөгжүүлэх замаар удирдлагын чанар үр өгөөжийг дээшлүүлэх.




- Зорилт 3.1** Нийгмийг соён гэгээрүүлэх, шинжлэх ухаан технологийн ололтыг сурталчлах, эрдэм мэдлэгийг тигээн дэлгэрүүлэх ийл ажиллагааг ергежүүлэх.
- Зорилт 3.2** Их сургуулийн орчинг иж бүрнээр хөгжүүлэх хетелберийг ие шаттайгаар хэрэгжүүлж, багш оюутнуудын ажиллах, суралцах, амьдрах таатай орчинг бичдүүлэх.
- Зорилт 3.3** Терийн бодлого, хетелберидийн шинжлэх ухааны иңдэслэлийг



- Зорилт 4.1** Байгууллагын гадаад болон дотоод орчинд гарч буй эрчимтэй еерчлелт, хөгжилтэй уялдаж удирдах багийн ур чадварыг сайжруулах, менежментийн шинэчлэлтийг хийх.
- Зорилт 4.2** ШУТИС-ийн хэмжээнд бичгийг оновчтой болгох, эрх мэдэл хариуцлагын хуваарилалтыг тегелдержүүлэх болон бичрэлдэхийний сургууль, нэгжидийн хоорондын харилцан уялдааг сайжруулах.
- Зорилт 4.3** Сургуулийн бичгээгдэхийний иңэлэмжийг дээшлүүлэх замаар санхүүгийн чадавхи, бие даасан байдлыг сайжруулах.
- Зорилт 4.4.** Удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хэрэглээний хүрээг өргөжүүлэх . (UNIMIS)

Менежментийн чадавхийг хөгжүүлэх замаар түүний чанар үр өгөөжийг дээшлүүлнэ.




**Зорилт 4.1** Байгууллагын гадаад болон дотоод орчны эрчимтэй еерчлелт, хөгжилтэй уялдуулж, удирдах багийн ур чадварыг сайжруулах, менежментийн шинэчлэлтийг хийх.

**Зорилт 4.2** ШУТИС-ийн хэмжээнд бiтцийг оновчтой болгох, эрх мэдэл хариуцлагын хуваарилалтыг тегелдержiiлэх, бiрэлдэхiiний сургууль хоорондын болон нэгжiiдийн хоорондын үйл ажиллагааны уялдааг сайжруулах.

**Зорилт 4.3** Сургуулийн бiтээгдэхiiний iнэлэмжийг дээшлiiлэх замаар санхiiгийн чадавхи, бие даасан байдлыг сайжруулах.

**Зорилт 4.4.** Удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналт-шинжилгээ, iнэлгээний тiвшинд хiргэж, тасралтгii хөгжiiлэх

Хүмүүн капиталын тогтвортой хөгжлийг хангаж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.




**Зорилт 5.1** Олон улсын хэмжээнд хiлээн зөвшөөрөгдсөн шилдэг тэргiiний профессор, багш, судлаачдаар хiний нэсцийг чанаржуулж, бэхжiiлэх

**Зорилт 5.2** Шударга өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжих замаар ажиллах хүчний идэвх санаачлагыг өрнүүлэх

**Зорилт 5.3** Хүн өөрөө тасралтгүй хөгжих орчинг бiрдiiлэх, iр бiтээлтэй ажиллах хөшүүргийг бий болгох замаар оюуны капиталыг арвижуулах

**Зорилт 5.4** Хамт олны телевизил, сэтгэл зiiн таатай уур амьсгалд тулгуурлан нийгмийн капиталын хөгжлийг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг авах

Олон улс, бүс нутгийн дээд боловсрол, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, оролцоог нэмэгдүүлж, байр сууриа бэхжiiлнэ.



**Зорилт 6.1** Олон улсын санхүүжүүлэгч, мэргэжлийн болон телееллийн байгууллагуудаар дамжуулан гадаад хамтын ажиллагааг ергежiiлж, гадаад тiншлэлийн сонирхлыг татах

**Зорилт 6.2** Гадаад хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрiiдийг хэрэгжiiлэх замаар сургалт, судалгааны материаллаг баазыг бэхжiiлэх

**Зорилт 6.3** Тодорхой мэргэжлээр гадаадын их дээд сургуулиудтай харилцан хiлээн зөвшөөрсөн сургалтын хөтөлбөр, оюутан багш нарын солилцоог нэмэгдiiлэх

# Гуравдугаар бүлэг. МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хэрэгжүүлэх стратеги зорилтууд	Үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд	Үр дүн ба шалгуур үзүүлэлтүүд
<p><b>Зорилт 1.1. Их сургуулийн сургалтын чанарыг дээшлүүлэх чиглэлд сургалтын үйл ажиллагааг төгөлдөржүүлэх</b></p>	<p><b>1. Мэдлэгийн зуун, глобал зах зээлийн эрэлт хэрэгцээ, улс орны хөгжлийн хэтийн төлөвт нийцүүлэн, бүтээлч сэтгэлгээтэй, чадварлаг мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэж, мэдлэгийн түвшинг баталгаажуулагч байна.</b></p> <ul style="list-style-type: none"><li>• Элсэгчдийн мэргэжил сонголтыг тодорхой хугацааны дараа оюутны хуримтлуулсан үнэлгээний голч дүнг (GPA) харгалзан, мэргэжлийн бодит сонголт хийлгэх</li><li>• Өндөр хөгжилтэй орнуудад оюутан үргэлжлүүлэн суралцах боломжийг өргөжүүлж, авьяас, чадвар сайтай оюутнуудыг сургалтын тусгай хөтөлбөрөөр суралцуулах</li><li>• Профессор багш нарын ур чадварыг сургалтын портфелийн бүрдэлтээр үнэлж, багшийн чадавхийг дээшлүүлэх</li><li>• Оюутан, төгсөгчдийн англи хэл, мэдээлэл, харилцаа холбооны технологийн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, сургалтын арга, технологийн дэвшилтэт хэлбэр, бүтээлч сэтгэлгээг дэмжин хөгжүүлэх</li><li>• Оюутны сурлагын чанарыг дээшлүүлэх, хүмүүжлийг төлөвшүүлэхэд чиглэсэн “XXI зууны оюутан” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх</li><li>• Үйлдвэрлэлийн дадлагын болон сургалтын материаллаг баазын шинэчлэлт, өргөжилтийг төсөл, хөтөлбөрийн хүрээнд үе шаттайгаар шийдвэрлэх</li><li>• Үйлдвэрлэлийн дадлагыг байгууллагуу-даар хийх боломжийг хангаж, чанар, өгөөжийг дээшлүүлэх зохион байгуулалтын механизмыг бүрдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах</li><li>• Их сургуулийн удирдлагын мэдээллийн системийн тусламжтайгаар сургалтын чанарын хяналтыг боловсронгуй болгох</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>• Суралцагчдын тоо</li><li>• Төгсөгчдийн тоо</li><li>• Ахисан түвшний суралцагчдын тооны өсөлт</li><li>• Суралцагчдын үнэлгээний голч дүн</li><li>• Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь</li><li>• E-Сургалт, нээлттэй их сургууль болох чиглэлд хийсэн ажлын үр дүн</li><li>• Олон улсын экспертээр үнэлгээ хийгдсэн сургалтын хөтөлбөрийн тоо</li><li>• Магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийн тоо</li></ul>
<p><b>Зорилт 1.2. Их сургуулийн сургалтын технологийг E-Сургалт, U-Сургалтын шинэ технологиор баяжуулж, сургалтын нэг үндсэн хэлбэр болгон төлөвшүүлэх замаар Нээлттэй их сургууль байгуулах үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх</b></p>	<ul style="list-style-type: none"><li>• Орон зай, цаг хугацаанаас хамааралгүйгээр уян хатан, олон хувилбартай, нээлттэй, хүртээмжтэй, чанартай, үр ашигтайгаар инженерийн боловсролын хэрэгцээг хангах тогтолцоог бий болгох</li><li>• Профессор, багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох хөтөлбөр, төсөл боловсруулж, хэрэгжүүлэх</li><li>• “Электрон сургалт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх</li><li>• E-Сургалт, U-Сургалтыг зохион байгуулан явуулах сургалтын орчин, тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүний асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх</li><li>• Номын сангийн цогцолборыг барьж олон</li></ul>	

улсын жишигт хүрсэн номын санг бий болгох  
• “Электрон номын сан” төсөл боловсруулж хэрэгжүүлэх

**Зорилт 1.3. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх, тэднийг насан туршийн суралцагч болгох сургалтын тогтолцоог боловсронгуй болгох**

- Төгсөгчдийг насан туршийн суралцагч болгох тогтолцоог бий болгож, хөгжүүлэх “Ахисан түвшний сургалт” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Профессорын баг - Ажил олгогч - Төгсөгчийн гурвалсан холбоог бэхжүүлэх, оюутны биржийг ажиллуулах
- Их сургуулийн нийт төгсөгчдийг “ ШУТИС-бидний бахархал” уриан дор нэгтгэх

**Зорилт 1.4. Дэлхий дахины дээд боловсролын төрөл бүрийн сүлжээнд нэгдэн орж, олон улсын түвшний шинжээчдээр сургалтын хөтөлбөрийг үнэлүүлж, дүгнүүлэх**

- Дэлхийн хөгжингүй орнуудын нийтлэг жишигт хүргэх чиглэлд инженерийн боловсролын стандарт, киррикулимыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийн үе шатаар үнэлэмжийг дээшлүүлэх
- Бэлтгэж буй мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдийг Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөр ээлж дараатайгаар магадлан итгэмжлүүлэх
- Гадаадын дээд боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөлүүдэд бэлтгэл хангагдсан хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх санал тавих
- Олон улс, бүс нутгийн их, дээд сургуулиудын консорциумд нэгдэх, хамтарсан хөтөлбөрүүдээр сургалт зохион байгуулах
- Гадаадын их, дээд сургуулиудтай оюутны мэдлэгийг үнэлэх системийг харилцан хүлээн зөвшөөрөлцөх гэрээг байгуулах, хамтран ажиллах

## **2.Эрдэм шинжилгээ, технологийн үйл ажиллагааг эрчимжүүлж, инновацийг дэмжиж, шинжлэх ухааныг хөгжүүлнэ.**

**Зорилт 2.1. Эрдэм шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэлийг оновчтой болгож судалгаа, туршилт зохион бүтээлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх.**

- Монгол улсын төрийн бодлогын холбогдох баримт бичгүүдтэй уялдуулан эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлүүдийг оновчтой тогтоох
- Тэргүүлэх чиглэл тус бүрээр төр, бизнесийн байгууллагуудтай хамтран хөгжлийн хөтөлбөр, төслүүд хэрэгжүүлэх
- Үндэсний хэмжээний судалгааны төвийг дотоод, гадаад хамтын ажиллагааны хүрээнд байгуулах
- Профессорын багийн үйл ажиллагааг дүгнэж, чансааг тогтоох, чадварлаг эрдэмтдэд түшиглэн профессорын баг байгуулах
- Профессорын судалгааны ажлыг дэмжих чиглэлд профессорын багийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох
- Профессорын багийн үйл ажиллагааг салбарын ШУТ-ийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх

**Зорилт 2.2. Профес-сорын багийн үйл ажил-лагааг төгөлдөржүүлэх.**

- Улсын төсвийн санхүүжилтанд тэргүүлэх чиглэлийн ажлын санхүүжилтийн эзлэх хувийн жин
- ШУТИС-ийн төсөвт эрдэм шинжилгээний зардлын хувийн жин
- Өндөр технологийн санхүүжилтийн эзлэх хувийн жин
- Сургалт судалгаа үйлдвэрлэлийн холбооны сайжралт (оюуны сүлжээ, инновацийн дэд бүтцийн

**Зорилт 2.3. Эрдэм шинжилгээний лаборатори, материаллаг баазыг бэхжүүлэх.**

- Сургалт-судалгааны нэгжүүдийг хөгжүүлэх, “Профессорын багийг төгөлдөржүүлэх” дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх
- Гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх
- Орчин үеийн судалгааны багажаар тоноглогдсон онолын суурь судалгааны нэгдсэн лаборатори байгуулах
- ШУТ-ийн тэргүүлэх чиглэлийн судалгааг олон улсын стандартын түвшинд гүйцэтгэх чадвартай эрдэм шинжилгээ, экспертизийн төвүүдийг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд байгуулах
- Нанотехнологи, геотехнологи, хиймэл оюун, оптик холбоо зэрэг дэвшилтэт технологийн чиглэлээр лабораториудыг шинээр байгуулах
- ЗГ-ын 2007 оны 306 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсад инновацийн тогтолцоог хөгжүүлэх” хөтөлбөр, “Дэвшилтэт технологийг хөгжүүлэх”, “Төрийн өмчийн их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаа, боловсруулалтын ажлыг дэмжих”, “Залуу судлаачдыг бэлтгэх, дэмжих” дэд хөтөлбөрүүдийн хүрээнд үйл ажиллагааг идэвхижүүлэх

**Зорилт 2.4. Оюуны капиталыг бизнесийн эргэлтэнд оруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, эрдэмтэд, судлаач багш, оюутнуудын судалгааны ажлын үр дүнг дэмжин урамшуулах**

- Оюуны өмчийн бүтээлийг бүртгэх, шалгуур үзүүлэлт, мэдээллийн санг бүрдүүлэх, түгээн дэлгэрүүлэх
- Судалгааны ажлын үр дүнг хамгаалах, нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх механизмыг боловсронгуй болгох
- Судалгааны ажлын үр дүнг арилжаалах, шинэ бүтээлийн патентыг лицензийн гэрээгээр ашиглуулах ажлыг эрчимжүүлэх

**Зорилт 2.5 Инновацийн дэд бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, технологи бизнесийн инкубаторуудыг байгуулах, уг чиглэлд их сургуулийн өөрийн нөөц боломжийг дайчлан ашиглах.**

- ШУТИС-ийг түшиглэн Технологийн инкубатор байгуулах, үйл ажиллагаанд нь аж ахуйн нэгжүүдийг өргөнөөр татан оролцуулах
- Монгол улсын аж үйлдвэрийн салбарын хөгжилд нэн шаардлагатай техник, технологийг нутагшуулах
- Эрдэмтэн судлаачид, бизнесийн байгууллагууд, олон нийтийг ШУТ-ийн шинэ мэдээллээр хангах, ЭШ-ний хурал, семинар, үзэсгэлэн, яармаг зохион байгуулах
- Улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжих төслийн захиалгыг чанаржуулах, ялангуяа аж ахуйн нэгжүүдтэй хамтрсан

өргөжилт)

- Оюуны өмчийн хамгаалалтын сайжралт
- Эрдэм шинжилгээний бүтээлийн арилжаанаас олох орлогын эзлэх жин
- Нийт суралцагчдын дотор магистрант, докторантын эзлэх хувийн жин

төслийг өргөжүүлэх, оюуны сүлжээ бий болгох

### **Зорилт 2.6. Магистрантур, докторантурын сургалт судалгааны ажлыг чанаржуулах.**

- Магистрант, докторантын судалгааны ажлын сэдвийн сонголтыг улс орны болон бизнесийн салбарын асуудлуудад хандуулж, бодит төсөл, төгсөлтийн ажил гүйцэтгүүлэх
- Оюутан багш нарын зохион бүтээх, туршилтын ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх,
- Онолын семинарыг магистрант, докторантуудын ШУ-ы судалгааны арга зүй эзэмших, онолын мэдлэгээ дээшлүүлэх, шинэ мэдлэгийн хүрээгээ өргөтгөхөд ашиглах сургалтын чухал хэлбэр болгох
- Магистрант, докторантуудыг төрөл бүрийн тэтгэлэгт хамруулах, тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлэх

## **3.Нийгэмд үзүүлэх үйлчилгээг бүх талаар чанаржуулж өргөжүүлнэ.**

### **Зорилт 3.1. Нийгмийг соён гэгээрүүлэх, шинжлэх ухаан технологийн ололтыг сурталчилах, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх.**

- Байгууллага, иргэдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, олон нийттэй харилцах нэгдсэн сүлжээ бий болгох
- Төгсөгчдийг ажлын байртай болгоход дэмжлэг туслалцаа үзүүлэх, зуучлах үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Нийгэмд үйлчлэхэд чиглэгдсэн хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах, хэрэгжүүлэх арга хэлбэр, зохион байгуулалтыг боловсронгуй болгох
- Олон нийттэй харилцах үйлчилгээний алба, нэгжүүдийн ажиллах орчинг сайжруулах, хариуцлагын тогтолцоог бий болгох
- Шинжлэх ухаан, технологийн хурал, үзэсгэлэн, уулзалт, сургалт семинарын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх
- Инженер, технологийн баримт бичиг боловсруулах, багаж төхөөрөмж, хэрэглэгдэхүүн материалыг бий болгох, инженер техникийн ажилтны мэргэшлийн баталгаажуулалтанд идэвхитэй оролцох

### **Зорилт 3.2 Их сургуулийн орчинг иж бүрнээр хөгжүүлэх хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлж, багш оюутнуудын ажиллах, суралцах, амьдрах таатай орчинг бүрдүүлэх.**

- Баянгол цогцолборын хүрээнд хотхон байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- ШУТИС-ийг орчин үеийн жишигтэй сургалт, судалгааны иж бүрэн орчинг бүрдүүлэх зураг төсөл, үндэслэлийг боловсруулах
- Хотхоноор хөгжих санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэхэд төрөөс дэмжлэг авах, уг чиглэлд сургуулийн санг бий болгох
- Төрийн бодлого, хөтөлбөр төслүүдийн

- Их сургуулийн хотхон бий болгох алхамууд хийгдэх
- Насан туршийн боловсрол олгох тогтолцооны төлөвшил
- Мэргэжлийн, арга зүйн болон төрийн бус байгууллагад гишүүнчлэлтэй багш нарын хувийн жин
- Олон улсын хэмжээнд тогтмол зохион байгуулагддаг, төрөлжсөн хурал, семинар, үзэсгэ-лэнгийн тоо

**Зорилт 3.3 Төрийн бодлого, хөтөлбөрүүдийн шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах болон нийгэм, бизнесийн хүрээний байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд профессор багш нарын оролцоог нэмэгдүүлэх**

шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад профессор багш нарын оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах

- Төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг төгөлдөржүүлэхэд профессор багш нарын оролцоог идэвхжүүлэх
- Профессор багш нарын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин, дэд бүтцийг бүрдүүлэх
- Тогтвортой хөгжлийг технологиор хангах тогтолцоо бий болгох иж бүрэн судалгаа явуулах
- Нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдол бүхий судалгаанд дэмжлэг үзүүлэх

**Зорилт 3.4 Мэргэжлийн болон ТББ-ын үйл ажиллагааг дэмжих замаар төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд ШУТИС-ийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх**

- Сургууль, профессор багш нарын зүгээс мэргэжлийн болон төрийн бус байгууллагын гишүүнчлэлээр ажиллах санаачлагыг дэмжих
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд сургалт, судалгааны бааз, багш судлаачдын хүчээр шууд оролцох болон зуучлах үйлчилгээг өргөтгөх
- ШУТИС-ийн нэрэмжит тэмцээн уралдааныг зохион байгуулах замаар өсвөр үеийнхний техник сэтгэлгээ, сонирхлыг өрнүүлэх
- Сургууль-ажил олгогч-төгсөгчдийн гурвал-сан холбоог бэхжүүлэхэд төгсөгчдийн үүргийг нэмэгдүүлэх.

#### **4. Менежментийн чадавхийг хөгжүүлж чанар үр өгөөжийг дээшлүүлнэ.**

**Зорилт 4.1 Байгууллагын гадаад болон дотоод орчны эрчимтэй өөрчлөлт, хөгжилтэй уялдуулж, удирдах багийн ур чадварыг сайжруулах, менежментийн шинэчлэлтийг хийх.**

- Удирдлагын бүрэлдэхүүний ур чадварыг дээшлүүлэх, шинэ мэдлэг мэдээллээр байнга хангах, мэргэшүүлэх систем бүрдүүлэх
- Гадаадын ба хил дамнасан (cross border education) сургуулийн менежментийг судалж, нэвтрүүлэх
- Эдийн засгийн удирдлага төлөвлөлтөнд хөрөнгийн, материалын, орон тооны үндэслэл сайтай нормативуудыг мөрдөж ажиллах
- Бүртгэл тайлан мэдээллийн оновчтой сүлжээ, сан бий болгож хөгжүүлэх
- Баримт бичгийн цахим үйл ажиллагааг бүрэн нэвтрүүлэх
- Сургуулийн хөгжлийн бодлогын дүн шинжилгээ, манлайллын удирдлагыг шинэ түвшинд гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх (хяналт, үнэлгээ

- Олон улсын стандартад ойртсон их сургууль болох. (Үндэсний хөгжлийн цогц бодлого)
- Удирдлагын ба санхүүгийн чадавхийн сайжралт,
- Их сургуулийн бүтцэд маркетинг, хяналт мониторингийн тогтвортой ажиллагаатай нэгж бий болсон байх.

мониторинг хийх чадавхийг хөгжүүлэх, бүтцийг бий болгох, удирдах албан тушаалын нээлттэй өрсөлдөөний зарчмыг хэрэгжүүлэх)

- Ажлын бодит гүйцэтгэл, ил тод байдал, урамшууллыг оновчтой уялдуудах механизмыг хэрэгжүүлэх (профессорын багийн рейтинг тогтоох гэх мэт)
- Удирдлагын бүх түвшинд маркетингийн удирдлагыг хэрэгжүүлэх үүднээс маркетингийн алба, нэгжийг бий болгох

**Зорилт 4.2 ШУТИС-ийн хэмжээнд бүтцийг оновчтой болгох, эрх мэдэл хариуцлагын хуваарилалтыг төгөлдөржүүлэх, бүрэлдэхүүний сургууль хоорондын болон нэгжүүдийн хоорондын үйл ажиллагааны уялдааг сайжруулах.**

- Хөгжлийн шаардлагад нийцүүлэн зохих шалгуур үзүүлэлт, нөхцөлийг харгалзан бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах журам боловсруулж мөрдөх
- Удирдлагын бүх түвшинд эрх мэдэл, үүрэг, хариуцлагын хуваарилалтыг төгөлдөржүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх
- Бүрэлдэхүүний сургуулиуд хоорондын үйл ажиллагааны уялдааг сайжруулах
- Удирдлагын нэгжүүд хоорондын ба профессорын багуудын хамтын ажиллагааны уялдааг хангах

**Зорилт 4.3 Сургуулийн бүтээгдэхүүний үнэлэмжийг дээшлүүлэх замаар санхүүгийн чадавхи, бие даасан байдлыг сайжруулах.**

- Сургалтын үйлчилгээний үнэлэмжийг нэмэгдүүлж, сургалтын төлбөрийг зах зээлийн эрэлтээр тодорхойлж байх боломжийг бүрдүүлэх (сургалтын төлбөрийг хүчээр барьдаг явдлыг зогсоох)
- Их сургуулийн дэргэд судалгаа, туршилт-үйлдвэрлэлийн нэгж байгуулах бизнесийн таатай орчныг бүрдүүлж, санхүүгийн чадавхийг дээшлүүлэх, корпорацжуулах бодлогыг хэрэгжүүлэх бодит боломжийг бүрдүүлэх
- Дотоод хуримтлалыг нэмэгдүүлж “ШУТИС хөгжлийн сан”-г арвижуулан, стратегийн ач холбогдолтой үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэхэд зохистой ашиглах.
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцон бүтээгдэхүүний үнэнд тусгах замаар хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг найдвартай бүрдүүлэх тогтолцоонд шилжих
- ШУТИС болон түүний бүрэлдэхүүн сургуулиудын санхүүгийн эрх мэдлийг өргөжүүлэх, бие даасан байдлыг сайжруулах
- Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд орлогоороо зардлаа нөхөн санхүүгийн хувьд бүрэн бие даасан байдлаар

**Зорилт 4.4. Удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналт-шинжилгээ, үнэлгээний түвшинд хүргэж, тасралтгүй хөгжүүлэх**

- ажиллуулах зарчмыг хэрэгжүүлэх
- “Засгийн газар- Их сургууль –Бизнес” гэсэн мэдээлэл солилцооны сүлжээг бий болгох замаар мэдээллийн орчин бий болгож, хамтын ажиллагааны хүрээг өргөтгөх
- Удирдлагын мэдээллийн систем дэх мэдээллийн экспорт, импортын агууламжийг дээшлүүлэх, шийдвэр боловсруулалт, гаргалт ба гүйцэтгэлийн хяналт, үр дүнгийн уялдааг сайжруулах
- Бүрэлдэхүүн сургуулиуд болон профессорын багуудын ВЭБ сайтын агуулга, үр өгөөжийг сайжруулж, англи хувилбартай болгон, үйл ажиллагааг тогтмолжуулах

## 5.Хүмүүн капиталын тогтвортой хөгжлийг хангаж өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

**Зорилт 5.1 Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг тэргүүний профессор, багш, судлаачдаар хүний нөөцийг чанаржуулж, бэхжүүлэх**

- Багшийн хөгжлийг үе шаттайгаар хангаж, эрдмийн зэрэг, цолтой багш нарын хувийн жинг нэмэгдүүлэх.
- Мэргэжлийн шавь сургуулийг хөгжүүлэх болон сонгон шалгаруулах зэргээр профессор багш нарын залгамж халааг бэлтгэх
- Өндөр хөгжилтэй орнуудад бэлтгэх магистр, докторын тоог нэмэгдүүлэх
- Өндөр хөгжилтэй орнуудад суралцаж, ажиллаж байгаа чадварлаг мэргэжилтнүүдийг татах хөшүүрэг, орчинг бүрдүүлэх.

**Зорилт 5.2 Шударга өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжих замаар ажиллах хүчний идэвх санаачлагыг өрнүүлэх**

- Профессор багш, ажилтан, ажилчдын ажлын ачааллыг оновчтой тогтоох болон ажлын үр дүнг бодитой үнэлэх замаар цалин хөлсийг өсгөж, үндсэн цалинг жил бүр инфляцийн түвшнээс багагүй хувиар нэмэгдүүлэх
- Профессорын багуудын чансаа тогтоох журмыг тэдний идэвхи санаачлагыг өрнүүлэх чиглэлээр боловсронгуй болгох
- Ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг албан тушаалын зэрэглэл, шагнал, урамшуулалтай нягт уялдуулах чиглэлээр аттестатчиллын тогтолцоог боловсронгуй болгох

**Зорилт 5.3 Хүн өөрөө тасралтгүй хөгжих орчинг бүрдүүлэх, үр бүтээлтэй ажиллах хөшүүргийг бий болгох замаар оюуны капиталыг арвижуулах**

- Профессор багш, ажилтнуудын ажиллах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, компьютер техник хэрэгслийн хангамжийг сайжруулах
- Багш нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлж, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлж, багшийг чадваржуулах, багшийн үнэлэмжийг дээшлүүлэхэд онцгой анхаарах
- Багш нарын англи хэлний болон мэдээллийн технологийн мэдлэгийг

- Докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жингийн өсөлт
- Эрдэм шинжилгээний ажилтнуудын чадавхи, бэхжилт
- Багш судлаачдын харилцан хөрвөх чадвар
- Багш ажиллагчдын орон сууцны хангамжийн түвшин
- Багш ажиллагчдын цалин, нийгмийн хангамжийн түвшний дээшлэлт

дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг жил бүр, үе шаттайгаар хэрэгжүүлж байх

- Багш нарыг сурган заах арга зүйн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх курс семинарт бүрэн хамруулах
- Багшийн ёс зүйг хангах, оюутны хүмүүжил төлөвшилд зохистой нөлөөлөх талаар онцгой анхаарч арга хэмжээ авч байх
- Нийт багш, ажиллагчдын хөдөлмөрийн үр дүн, ажлын гүйцэтгэлтэй уялдуулан зөв үнэлгээ явуулж байх “Ажлын үр дүн ба урамшуулал, хариуцлагын нэгдсэн систем” боловсруулан мөрдөж ажиллах
- Нийт багш, ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, ялангуяа багш нарын орон сууцны хангамжийг сайжруулах асуудлыг төр, засгийн бодлоготой уялдуулан орон сууцны хөтөлбөрт хамруулах асуудлыг бодит ажил болгон хэрэгжүүлэх
- Багш, ажиллагчдад нийгмийн халамж, үйлчилгээг цаг тухай бүр хүргэж байх
- Багш нарыг гадаадад мэргэжил дээшлүүлэх, суралцах, туршлага судлах боломжоор хангах асуудлыг үе шаттайгаар, өргөн хүрээнд шийдвэрлэх
- Ахмад настнуудад тавих анхаарал халамж болон сэтгэл санааны дэмжлэгийг цаг тухайд нь дүрэм, журмын дагуу үзүүлж байх
- Багшлах бүтэц, бүрэлдэхүүнийг чанаржуулах
- Гадаадад ажиллаж байгаа чадварлаг судлаачид, багш нарыг сургуульд ирж ажиллах сонирхлыг төрүүлэх, хөшүүрэг бий болгох, нөхцөл боломжийг хангахад анхаарч ажиллах
- Хамт олны эрэлт хэрэгцээ, санал бодлыг судлах асуулгыг захиргаанаас ба багш нарын зөвлөлөөс тогтвортой явуулдаг болох, удирдлагын шийдвэрт тусгуулах зарчмыг хэрэгжүүлэх
- ШУТИС-ийн тогтвортой хөгжлийн ирээдүй, үнэт зүйлсийг хамт олон эрхэмлэн дээдэлдэг, түүний төлөө идэвхи санаачлагатай ажилладаг уур амьсгалыг бүрдүүлэх
- Хамт олны доторхи сэтгэл зүйн таатай уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэсэн спорт, соёл, хүмүүжлийн үйл ажиллагаануудыг уламжлал, шинэчлэлийн үүднээс тогтвортой явуулах
- Хөгжлийн зорилгод чиглэсэн багш, ажилтны нийгмийн янз бүрийн бүлгийн

**Зорилт 5.4 Хамт олны төлөвшил, сэтгэл зүйн таатай уур амьсгалд тулгуурлан нийгмийн капиталын хөгжлийг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг авах,**

хэлбэрүүдийн (клуб, холбоо, сүлжээ, иргэний нийгмийн байгууллагын) үйл ажиллагааг дэмжих, удирдлагад өргөнөөр татан оролцуулах

## **6.Олон улс, бүс нутгийн дээд боловсрол, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, оролцоог нэмэгдүүлж, байр сууриа бэхжүүлнэ.**

**Зорилт 6.1 Олон улсын санхүүжүүлэгч, мэргэжлийн болон төлөөллийн байгууллагуудаар дамжуулан гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаад түншлэлийн сонирхлыг татах**

**Зорилт 6.2 Гадаад хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар сургалт, судалгааны материаллаг баазыг бэхжүүлэх**

**Зорилт 6.3 Тодорхой мэргэжлээр гадаадын их дээд сургуулиудтай харилцан хүлээн зөвшөөрсөн сургалтын хөтөлбөр, оюутан багш нарын солилцоог нэмэгдүүлэх.**

- Монгол Улсын Засгийн газраас НҮБ, ЮНЕСКО, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Европын Холбоотой хамтран хэрэг-жүүлж буй хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд оролцох
  - Олон улсын мэргэжлийн нийгэмлэг, төрийн бус байгууллагуудаар дамжуулан гадаад харилцаагаа хөгжүүлэх
  - Өндөр хөгжилтэй орнуудад суралцаж төгссөн, эрдмийн зэрэг хамгаалсан профессор, багш нараар дамжуулан гадаад харилцааг өргөжүүлэх
  - Бүс нутгийн сургуулиудын хамтын ажиллагааны сүлжээнд нэгдэх, бренд хөтөлбөх бий болгох
  - Гадаадын их дээд сургууль, бизнесийн байгууллагуудтай хамтарсан технологийн парк, сургалтын төвүүдийг байгуулах
  - Сургалт, эрдэм шинжилгээний материаллаг баазыг бэхжүүлэхэд гадны хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж, хувь оролцоог нэмэгдүүлэх
  - Төрийн өмчтэй их сургуулиудад гадаадын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд санаачлагатай ажиллах.
  - Сэндвич хөтөлбөр хэрэгжүүлж, оюутан солилцооны үйл ажиллагааг өргөжүүлэх
  - Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтдийг урьж ажиллуулах, өөрийн профессор багш нарыг гадаадад мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллахад нь дэмжлэг үзүүлэх
  - Олон улсын хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд профессор багш нарын оролцоог нэмэгдүүлэх
  - Гадаад, дотоодын оюутнуудад зуны сургалтын тусгай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх
  - Гаднаас урьж ажиллуулах нарийн мэргэжлийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх.
  - Багш, оюутныг дотоод гадаадын нэр хүндтэй тэмцээн уралдаанд оролцуулах
- Бүс нутгийн их, дээд сургуулиудын сүлжээнд орсон байх
  - Гадаадтай хамтарсан сургалтын хөтөлбөрийн тоо
  - Хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлдэг бүрэлдэхүүн сургуулиудын хувийн жин
  - Хэрэгжүүлж буй олон улсын томоохон төсөл хөтөлбөрүүдийн тоо
  - Гадаадад урилгын профессороор болон судлаачаар ажилласан багш нарын тоо
  - Гадаадаас суралцаж байгаа оюутны тоо

<b>Нэгдсэн шалгуур үзүүлэлт</b>	<b>Сургалтын чанар сайжирч, бүтээлч, чадварлаг мэргэжилтэн, судлаачдын тоо нэмэгдэнэ.</b>
	<b>Шинжлэх ухаан, инноваци хөгжиж, оюуны капитал бизнесийн эргэлтэнд орно.</b>
	<b>Нийгмийн үйлчилгээ өргөжнө.</b>
	<b>Менежментийн ба санхүүгийн чадавхи сайжирна.</b>
	<b>Хүмүүний болон нийгмийн капиталын үнэ цэнэ өсч, оюуны капитал арвижна.</b>
	<b>Олон улсын, бүс нутгийн хамтын ажиллагааны үүрэг нэмэгдэж, нэр хүнд өснө.</b>
<b>Олон улсын жишигт нийцсэн их сургууль болно.</b>	

## Дөрөвдүгээр бүлэг. МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ХЯНАЛТ-ҮНЭЛГЭЭ БА САНХҮҮГИЙН НӨӨЦ

### 4.1. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, хяналт, үнэлгээ

ШУТИС-ийн ректорын зөвлөл, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, профессорын багуудын үйл ажиллагааг Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай оройлон манлайлах чадавхитай болгох хэмжээнд хүртэл шинэчлэн сайжруулах нь уг бодлого стратегийг хэрэгжүүлэх угтвар нөхцөл болно. Ректорын зөвлөл, ректор, бүрэлдэхүүн нэгжүүдийн захирлууд нь дунд болон богино хугацааны бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрүүдээ уг Мастер төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, биелэлтийг нь зохион байгуулж ажиллана.

Ректорын зөвлөл Мастер төлөвлөгөөний хүрээнд бүрэлдэхүүн сургууль, газар, нэгж бүрийг бодлогын удирдлагаар хангаж, дор дурдсан хөтөлбөр, төслүүдийг боловсруулан салбар нэгж хооронд уялдуулан зохицуулж, хэрэгжүүлнэ. Үүнд:

- Эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх хөтөлбөр /2007-2015 он/
  - А. “Инноваци, инкубатор, инженер” дэд хөтөлбөр
  - Б. “Профессорын багийг төгөлдөржүүлэх” дэд хөтөлбөр
- “Электрон сургалт” хөтөлбөр
- “Е-Номын сан” хөтөлбөр
- “Ахисан түвшний сургалт” хөтөлбөр
- “Багшийн хөгжил” хөтөлбөр
  - А. “Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо” дэд хөтөлбөр
  - Б. “Орон сууц, оюутны байр” дэд хөтөлбөр
- “XXI зууны оюутан” хөтөлбөр
- “ШУТИС-хотхон” хөтөлбөр
- “Судалгаа, сургалтын шинэ орчин” бүрэлдэхүүн сургуулиудад хэрэгжих төсөл
- Бусад хөтөлбөр, төслүүд

Дээрхи хөтөлбөр, төслүүдийг чанартай, бодитой боловсруулж, үр дүнд хүрэх үүднээс хамт олны дунд тендер зарлах замаар мэргэшсэн багш, судлаачдын хүчийг төвлөрүүлэх бодлого баримтлах нь зүйтэй юм. Мастер төлөвлөгөө, түүнтэй холбогдох хөтөлбөр, төслүүдийг боловсруулах ажлыг шуурхай удирдлагаар хангаж, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүргийг хариуцах нэгжийг захиргааны бүтцэд байгуулан ажиллуулах шаардлагатай байна.

Мастер төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухай бүр хяналт-шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаварыг үнэлж дүгнэх ажлыг 2 үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

I үе шат: Мастер төлөвлөгөөний эхний үе шатны үнэлгээ хийх.

Хугацаа: 2011 оны 01-р сар

II үе шат: Мастер төлөвлөгөөний эцсийн шатны үнэлгээ

Хугацаа: 2015 оны 12-р сар

Мастер төлөвлөгөөний тухайн шатны хэрэгжилтийн үнэлгээг тайлангийн хэлбэрээр боловсруулж, завсрын болон дээр заагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацаанд

ректоратаар хэлэлцүүлж байна. Мөн ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл Мастер төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэнд байнга хяналт тавина. Мөн ШУТИС-ийн дунд болон богино хугацааны бизнес төлөвлөгөөнүүдэд уг мастер төлөвлөгөөг хянан сайжруулж, тухай бүр ректоратод оруулан баталгаажуулах боломжтой.

#### 4.2. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн нөөц ба эрсдэл

“ШУТИС-2015 он” Мастер төлөвлөгөөнд тусгагдсан тодорхой зорилго, зорилтуудыг хангахад хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай болно. Нэгдүгээр үе шат буюу 2010 он хүртэл хугацаанд 28.1 млрд төгрөг, хоёрдугаар үе шат буюу 2011-2015 он хүртэл хугацаанд 46.9 млрд төгрөг, нийтдээ 75.0 млрд төгрөгийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ байна. Тооцооноос үзэхэд ШУТИС өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэлэмжийг дээшлүүлж, нөөц бололцоогоо дайчилбал 21 млрд. төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх бололцоотой. Үлдэх хэсгийг бусад эх үүсвэрээс, тухайлбал, улсын төсвөөс 30.0 млрд. төгрөгийн, гадаад дотоодын хөтөлбөр, төслийн хөрөнгө, хандиваас 24.0 млрд төгрөгийг бий болгоно гэж тооцоолж байна. Уг хөрөнгө оруулалтыг хийснээр 2015 онд суралцах оюутны болон ажиллах багш, ажиллагчдын хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг манай сургууль хангах боломжтой болох юм.

Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад доор дурьдсан эрсдэл тохиолдож болохыг анхаарах нь зүйтэй. Үүнд:

1. Төр засгийн үйл ажиллагаанаас хамаарах эрсдэл
  - Төрийн удирдлагын чадавхи сул болон урт хугацаанд сайжрахгүй байх.
  - Шинжлэх ухаан, боловсролын харилцааг зохицуулах эрх зүйн зохи-цуулалт хангалтгүй, батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилт сул байх.
  - Их, дээд сургуулийн эрх зүйн статус тодорхой бус байгаа нь удаан хугацаанд үргэлжлэх.
2. Нийгэм, эдийн засгийн орчноос хамаарах эрсдэл
  - Эдийн засгийн өсөлт буурах, санхүү төсвийн хямралд орох.
  - Хүн амын амьдралын түвшин дээшлэхгүй байх, ядуурал, ажилгүйдлийн түвшин нэмэгдэх.
  - Авилгал өргөжих, нийгмийн хямрал гүнзгийрэх.
3. Байгууллагын дотоодод гарч болох эрсдэл
  - ШУТИС-ийн хэмжээнд эрх мэдлийн төвлөрөл, шилжүүлэлт, бүрэлдэхүүн сургуулиудын бие даасан байдлыг хангах удирдлагын зохистой харилцаа бүрдэхгүй байх, нэг чиглэлийн удирдлагын харилцаа давамгайлах, дунд анхан шатанд хариуцлага сулрах.
  - Багш, ажилтны хөдөлмөрийн үнэлэмж, урамшуулал, хариуцлага тооцох систем оновчтой бусаас чанарын төлөө шударга өрсөлдөөн бий болохгүй байх, тогтвор суурьшил буурах, улмаар үйлчилгээний чанар үр нөлөө дээшлэхгүй байх.
  - Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт үнэлгээний бүтэц байгуулагдахгүй байх буюу байгуулагдсан ч сайн ажиллахгүйгээс төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, эрчимжүүлэх ажил хангалтгүй явагдах, үр өгөөж нь муудах

#### “ШУТИС-2015 он” Мастер төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтүүд

	Шалгуур үзүүлэлтүүд	2006 оны	Хүрэх түвшин
--	---------------------	----------	--------------

№		байдлаар	2010 онд	2015 онд
1.	Нийт суралцагчдын тоо	21227	23438	24350
	үүнээс: - бакалаврын оюутан	19449	20569	20200
	- магистрант	947	1690	2150
	- докторант	831	1179	2000
2	Бакалаврын оюутнуудын сурлагын голч дүн	2.72	2.76	2.9
3.	Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин	74.5%	80%	90%
4.	Нийт багшийн тоо	809	954	1135
5	Багш оюутны тооны харьцаа	1:26	1:21	1:15
6	Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	28	40	50
7	Багш нарын дундаж цалингийн өсөлтийн хувь / 2006 оныг суурь болгов/	30*	100	200
8	Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан багш, судлаачдын тоо	205	250	750
	Үүнээс: гадаадад	115	149	500
	дотоодод	90	101	250
9	Е-сургалтын хөтөлбөрийн тоо	12*	26	39
10	Магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийн тоо	3	26	35
11	Шинээр байгуулах ба шинэчлэх лабораторийн тоо	9	22	33
12	Судалгаа, сургалтын лабораторийг байгуулах, материаллаг баазыг бэхжүүлэхэд зарцуулах улсын төсвийн хөрөнгө оруулалт /сая. төг./	-	500.0	2700.0
13	Нэг компьютерт ногдох оюутны тоо	12*	10	6
14	Нийт зардалд эрдэм шинжилгээний зардлын эзлэх хувь	9.1*	14.2	15.0
15.	Улсын захиалгаар гүйцэтгэх төслийн санхүүжилтийн өсөлт /суурь он 2007 он/	100%*	130%	200%
16	Патентын тоо	10	12	16
17	Ашигтай загварын гэрчилгээний тоо	15	18	24
18	Зохиогчийн эрхийн гэрчилгээний тоо	12	15	25
19	Улсын бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлийн тоо	4	6	10
20	Гадаадын нэр хүндтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүдэл	93	120	170
21	Гадаадтай хамтарсан сургалтын хөтөлбөрийн тоо	4	7	9
22	Хамтын ажиллагааны харилцаа холбоо тогтоосон гадаадын сургууль, байгууллагын тоо	208	232	240
23	Хэрэгжүүлж буй олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн тоо	18	22	28
24	Гадаадаас урилгын профессороор болон судлаачаар ажилласан хүний тоо	20	40	60
25	Гадаадаас суралцаж байгаа оюутны тоо	22	42	62

Тайлбар: \* - 2007 оны тоо

---о О о---

**“ШУТИС-2015 он Мастер төлөвлөгөө”- г  
боловсруулсан ажлын хэсэг**

1. Ажлын хэсгийн ахлагч: **Г.Даваажаргал** - ЭЗНХ-ийн проректор
2. Орлогч дарга: **Б.Даваасүрэн** - ҮТДС-ийн захирал, док., проф
3. Нарийн бичгийн дарга: **С.Төгс** - СЭЗГ-ын дарга, док., дэд проф
4. Гишүүн: **Я.Наранцэцэг** - СБЗГ-ын дарга, док., дэд проф
5. **О.Балдангомбо** - ХМТС-ийн профессор, док., проф
6. **Б.Очирхуяг** - ХБТС-ийн захирал, док.,
7. **Т.Намнан** - МС-ийн профессор, док., дэд проф
8. **Д.Энхбат** - ШУТГ-ын ахлах мэргэжилтэн, док.,
9. Туслах ажилтан: **Л.Батсүрэн** - СЭЗГ-ын эдийн засагч

### **Хавсралтууд:**

Хавсралт №1 – А. ШУТИС-ийн хөгжлийн үзүүлэлтүүдийн эмхэтгэл /1997-2007 он/  
Б. ШУТИС-ийн өнөөгийн нөхцөл байдлын оношлогоо, дүгнэлт  
/2006 оны байдлаар/

Хавсралт №2 – ШУТИС-ийн 2010 он хүртэлх Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал

Хавсралт №3 – ШУТИС-ийн 2010 он хүртэлх Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн  
байдалд хийсэн асуулга судалгааны нэгтгэл